**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2022 оны 02 сарын 14 өдөр Дугаар А/30 Мандалговь

"Ариун Мед Трейд" ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 67 дугаар зүйл 67.5, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/08 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Мэргэжлийн хяналтын газарт кьелдаль багаж болон пестицидийн үлдэгдэл тодорхойлох багаж нийлүүлэх" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Ариун Мед Трейд" ХХК-тай 44,640,000 /дөчин дөрвөн сая зургаан зуун дөчин мянга/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу Мэргэжлийн хяналтын газарт кьелдаль багаж болон пестицидийн үлдэгдэл тодорхойлох багаж нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Ариун Мед Трейд" ХХК-ний захирал (Э.Майцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

4322150070